



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2010 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

**Тушаалд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад сургах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 336 дугаар тушаалын Дашдондогийн Бат-Эрдэнэтэй холбогдолтой хэсгийн “АНУ-ын Жорж Мейсоны их сургуульд” гэснийг “АНУ-ын Виржиниа мужийн Стрэйэрийн их сургуульд” гэж, “Гадаадад зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 294 дүгээр тушаалын Оюунболд овогтой Ганчимэгтэй холбогдолтой “АНУ-ын Харвардын их сургуулийн магистрантурт удирлагын чиглэлээр” гэснийг “Австралийн Үндэсний их сургуулийн магистрантурт худалдааны чиглэлээр 2 жилийн хугацаагаар” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасгай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР